

3. Жагсаалт, хайлттай ажиллах

Жагсаалт, хайлттай ажиллах хэсэгт мэдээллийг оновчтой хайх, нарийвчлан шүүх болон тухайн мэдээлэл дээр үйлдэл хийх боломжийг олгоно.

Жагсаалт, хайлтын цонх нь дараах бүтэцтэй байна.

Тайлбар:

- **Түлхүүр үгээр хайх**

Жагсаалтаас ямар нэгэн түлхүүр үгээр хайх боломжийг олгоно. Жишээ нь суралцагчийн жагсаалтнаас регистрийн дугаар, овог, нэр, мэргэжлийн чиглэл,... зэргээр хайж болно.

- **Нарийвчилсан шүүлтийн хэсэг**

Нарийвчилсан шүүлт нь хайлтын үр дүнг нарийвчлан тодорхойлох боломжийг олгох ба тухайн жагсаалтад боломжтой шүүлтийн төрөл болон шүүх утгаар шүүлт хийнэ.

- **Нарийвчилсан шүүлтийн төрөл**
- **Нарийвчилсан шүүлтийн утга**

- **Жагсаалтын толгойн хэсэг**

Жагсаалтын толгойн хэсэгт тухайн жагсаалтын нэр, тухайн жагсаалт дээр хийх боломжит үйлдлийн сонголтууд байна.

- **Жагсаалтын нэр**
- **Жагсаалт дээр хийх үйлдлүүд**

- **Хайлт, шүүлтийн мэдээлэл**

Хайлт хийх болон нарийвчилсан шүүлт хийснээр хайлтын олдоцийн тоо, ямар ямар шүүлт хийснийг илэрхийлсэн мэдээллээр хангана.

- **Хайлтын олдоцийн тоо**
- **Нарийвчилсан шүүлт**

- **Хайлт, шүүлтийн үр дүн**

Хайлт болон шүүлт хийснээр олдсон олдоцийн мэдээллийг харуулах ба тухайн мэдээлэл дээр үйлдэл хийх боломжийг олгоно.

- **Үйлдэл хийх цэс**
- **Түгжсэн багана**
- **Хуудасны дугаар**
- **Хуудас шилжих**
- **Хуудаслах тоо**